НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 02 өдөр | Дугаар А/39 | Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3,13.3.6, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн тусгай зориулалтын автомашинтай сургалтыг Төв, Говь-Сүмбэр, Дорноговь аймгийн Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдад 2019 оны 05 дугаар сарын 05-13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, сургалт зохион байгуулах бүрэлдэхүүнийг хоёрдугаар, сургалт зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтад шаардагдах 2.791.000 (хоёр сая долоон зуун ерэн нэгэн мянга) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалтын үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангаж, зохион байгуулж, дүнг 05 дугаар сарын 17-ны өдрийн дотор илтгэх хуудсаар танилцуулахыг Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв (хурандаа Г.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

1117155601
УХА0038 9077073

D/:My documents-blank-2019-tushaal

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн
А/59 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ӨМНӨД БҮСИЙН АЙМГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

1. Сургалтын зорилго: Гамшгаас хамгаалах сургалтын төвийн үйл ажиллагааг сурталчлах, гамшгийн эрсдэлийг бууруулах, аюул ослоос урьдчилан сэргийлэх хүрээнд Төв, Говь-Сүмбэр аймаг, Дорноговь аймгийн Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдын иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг, хандлага, дадал олгох.

2. Сургалтын сэдэв: Газар хөдлөлтийн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, утаат орчноос дүрвэх, нэрвэгдэгсдэд амилуулах суурь тусламж үзүүлэх.

3. Сургалт зохион байгуулах аймгууд: Төв, Говь-Сүмбэр аймаг, Дорноговь аймгийн Сайншанд, Айраг, Замын-Үүд сум

4. Хамрах хүрээ: Төв, Говь-Сүмбэр аймаг, Дорноговь аймгийн Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, ажилтан албан хаагчид, иргэд.

5. Сургалт зохион байгуулах хугацаа: 2019 оны 05 дугаар сарын 05-аас 13-ны өдөр

6. Зохион байгуулах хичээлийн сэдэв:

| № | Хичээлийн нэр | Ноогдох /минут/ | Хэрэглэгдэхүүн | Хариуцах багш |
|---|---|---|---|---|
| 1 | Газар хөдлөлт | /180/ | - үзүүлэн таниулах материал,<br>- газар хөдлөлтийн танхимын сургалтын цүнх,<br>- сургалтын автомашин | д/ч Б.Ням-Осор |
| 2 | Утаат орчин | /120/ | - утаат шашка /цагаан/,<br>- сургалтын автомашин | А/д Б.Солонго |
| 3 | Гал унтраах | /120/ | - нунтаг гал унтраагуур,<br>- гал унтраах техник хэрэгсэл,<br>- сургалтын автомашин | д/ч Б.Ням-Осор |
| 4 | Анхан шатны тусламж | /120/ | -сургалтын том хүний 4, хүүхдийн 2 манекен,<br>- бинт,<br>- амбуу | д/ч У.Амарсайхан |
| 5 | Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоо | /60/ | -Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо ба хариуцлага сэдэвт үндэсний семинарын гарын авлага | д/ч У.Амарсайхан |
| | | **НИЙТ** /600/ | | |

--oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн
А/39 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

117155601
КА0038 9077073

# СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

1. Багийн ахлагч

| д/д | Овог нэр | Цол | Албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | Д.Мөнхбат | Дэд хурандаа | Менежер |

2. Багшлах бүрэлдэхүүн

| № | Цол | Албан тушаал | Нэр |
|---|---|---|---|
| 1 | а/д | Сургагч- багш | Б.Солонго |
| 2 | д/ч | Сургагч- багш | У.Амарсайхан |
| 3 | д/ч | Сургагч- багш | Б.Ням-Осор |
| 4 | а/ч | Техникч | С.Жанчив |
| 5 | а/ч | Жолооч | Ю. Бат- Эрдэнэ |

--oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн
A/39 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

# СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

1. Шатахууны зардал

| Авто машины марк | Явах чиглэл | Хоорондын зай /км/ | 100км-т зарцуулах шатахуун шатахуун | Хэдэн литр | Мот оцаг /л/ | Мото цаг /хугацаа/ | Хэдэн литр | Нийт шатахууны үнэ | 1 литр шатахууны үнэ | Нийт зарцуулах шатахуун /үнэ/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48-89 УБН | Улаанбаатар-Говьсүмбэр | 244.6 | 45 | 110.07 | 20 | 3 | 60 | 170 | 2370 | 403,000 |
| | Говьсүмбэрээс- Айраг сум | 122.4 | 45 | 55.08 | 20 | 3 | 60 | 115 | 2370 | 273,000 |
| | ДГ,Айраг сум-Сайншанд | 125.9 | 45 | 56.655 | 20 | 3 | 60 | 117 | 2370 | 276,000 |
| | Сайншанд-Замын-үүд | 212 | 45 | 95.4 | 20 | 3 | 60 | 155 | 2370 | 368,000 |
| | Замын-үүд-Төв аймаг | 730.6 | 45 | 328.77 | 20 | 3 | 60 | 389 | 2370 | 920,000 |
| | Төв аймаг-Улаанбаатар | 45 | 45 | 20.25 | | | | 20 | 2370 | 48,000 |
| 08-84 УБН Toyota harrier | Улаанбаатар-Говьсүмбэр | 300 | 18 | 54 | - | - | 0 | 54 | 1860 | 100,000 |
| | Говьсүмбэрээс- Айраг сум | 100 | 18 | 18 | - | - | 0 | 18 | 1860 | 33,000 |
| | ДГ,Айраг сум-Сайншанд | 130 | 18 | 23.4 | - | - | 0 | 23 | 1860 | 43,000 |
| | Сайншанд-Замын-үүд | 200 | 18 | 36 | - | - | 0 | 36 | 1860 | 67,000 |
| | Замын-үүд-Төв аймаг | 730 | 18 | 131.4 | | | | 131 | 1860 | 245,000 |
| | Замын-үүд-Улаанбаатар | 45 | 18 | 8.1 | - | - | 0 | 8 | 1860 | 15,000 |
| **Нийт дүн** | | | | **937.125** | | | | | | **2,791,000** |

--oOo---